



ХАМРАХ ХҮРЭЭ

- Сэлэнгэ аймгийн Баянгол сум
- Сэлэнгэ аймгийн Мандал сум
- Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл тосгон
- Ховд аймгийн Алтай сум
- Говь-Алтай аймгийн Есөнбулаг сум



АЛТНЫ БИЧИЛ УУРХАЙН ТООН МЭДЭЭЛЛҮҮД



ХОЛБОО БАРИХ:

📍 Хүннүгийн гудамж - 906, Их Монгол оффис
Баянзүрх дүүрэг, 26-р хороо
Улаанбаатар хот, 13311

☎ +976 77225588, 77559695
✉ npm.mn@artisanalgold.org
📘 [pGOLDmongolia](https://www.pGOLDmongolia.com)
📺 [planetGOLD_MN](https://www.planetGOLD_MN.com)
🌐 [planetGOLD.org](https://www.planetGOLD.org)
🌐 [artisanalgold.org](https://www.artisanalgold.org)



¹ Ашигт малтмал, газрын тосны газар, <https://www.mrpm.gov.mn/public/pages/133/2019.09-mon.pdf>
²⁻⁴ ШХА, Тогтвортой бичил уурхай төсөл, <http://www.sam.mn>

ТӨСЛИЙН ТУХАЙ

Алтны бичил уурхай нь дэлхийн нийт алтны үйлдвэрлэлийн 15-20%-ийг бүрдүүлдэг хэдий ч салбарын 80% нь албан бус секторт хамаарч мөнгөн усны ялгарлын хамгийн том эх үүсвэр (37%) болж байна.

Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй мөнгөн усны ялгарал, бохирдлоос хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах зорилгоор Мөнгөн усны тухай Минаматагийн конвенц батлагдсан. Одоогоор уг конвенцод нийт 128 орон нэгдэн орсноос 123 орон соёрхон батлаад байна. Монгол Улс 2015 онд уг конвенцыг соёрхон баталж, энэхүү олон улсын гэрээнд албан ёсоор нэгдэн орсон.

Тус конвенцын 7-р зүйл болон Хавсралт В-д алтны бичил уурхайтай холбогдох заалт, хүлээх үүрэг амлалтуудыг тусгасан. Минаматагийн конвенцын 7-р зүйлийг хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, алтны бичил уурхай дахь мөнгөн усны хэрэглээнээс үүдсэн үндсэн асуудлуудыг хөндөх, тогтвортой хөгжлийн боломжоор хангах зорилгоор Даян дэлхийн байгаль орчны сангаас planetGOLD хөтөлбөрийг 8 улсад санхүүжүүлэн хэрэгжүүлж байна.

Хөтөлбөрийн хүрээнд planetGOLD Монгол төсөл 5 жилийн (2019-2023) хугацаатай хэрэгжиж байна. Төслийг НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага хэрэгжүүлж байгаа бөгөөд Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Канад Улсын Алтны бичил уурхайн зөвлөл хамтран гүйцэтгэж байна.



БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 1 АЛБАЖУУЛАЛТ

Алтны бичил уурхайн эрх зүйн орчныг сайжруулахад чиглэсэн бодлого журам, арга хэрэгслийг боловсруулахад дэмжлэг үзүүлж, төрийн байгууллагын ажилтнууд болон бичил уурхайчдыг чадавхжуулна.

Хүлээгдэж буй үр дүн: Засгийн газраас бичил уурхайг албажуулах чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ, дэмжлэг туслалцааг бичил уурхайчид хүртэх хүртээмж нэмэгдсэн байна.



БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 2 САНХҮҮ, ЗАХ ЗЭЭЛИЙН ХҮРТЭЭМЖ

Алтны нийлүүлэлтийн сүлжээг албажуулахад хувь нэмэр оруулж, хариуцлагатай үйл ажиллагаа эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор зээлийн сан байгуулан, бичил уурхайчдыг хөрөнгө оруулагчидтай холбоно.

Хүлээгдэж буй үр дүн: Засгийн газраас алтны бичил уурхайн сан байгуулах ажлыг дэмжсэнээр бичил уурхайч мөнгөн усгүй технологид хөрөнгө оруулах, алтны хариуцлагатай зах зээлд оролцох боломж бүрэлдсэн байна.



БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 3 ТЕХНОЛОГИ САЙЖРУУЛАЛТ

Мөнгөн усгүй, байгаль орчинд нөлөө багатай аргаар алтны хүдэр боловсруулах технологийг туршин нэвтрүүлж, олборлолт, баяжуулалтын арга технологи, байгаль орчны удирдлага, жендерийн тэгш байдлын талаарх сайн туршлагыг түгээж, чадавхыг бий болгоно.

Хүлээгдэж буй үр дүн: Монгол Улсад алтны бичил уурхайгаас үүдэлтэйгээр үүсч буй мөнгөн усны ялгарлыг бууруулсан байна..



БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 4 МЭДЛЭГИЙН МЕНЕЖМЕНТ

Олон нийтийн платформ, хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан бичил уурхайн салбарын оролцогч талуудад мэдлэг, мэдээлэл түгээж, бичил уурхайн ололт амжилт, сайн туршлагыг үндэсний болон олон улсын түвшинд сурталчлан таниулна.

Хүлээгдэж буй үр дүн: Мэдлэг, мэдээллийг бүх бичил уурхайчдад хүргэх арга замыг төсөл хэрэгжих орон нутаг болон төрийн байгууллага хамтран тодорхойлсон байна. Төслийн хүрээнд боловсруулж гаргасан мэдээллийг planetGOLD хөтөлбөрөөр дамжуулан олон улсын түвшинд ашигласан байна.